

Golomt Capital®

Хөрөнгийн Зах зээлийн Тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2024.03.04

Олон улсын
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

2024 он 03 сарын 04


- АНУ-ын Хувийн хэрэглээний индекс /PCE/ 2.8 хувь буюу хүлээлтийн дагуу гарлаа
- БНХАУ-ын зах зээлийн тоон үзүүлэлтүүд Цагаан сарын амралтын өдрүүдтэй холбогдуулан суларсан байна
- БНХАУ-ын ТОП 100 барилгын компанийн ҮХХ борлуулалт 2-р сард өнгөрсөн оноос 60% буурав
- Газрын тос олборлогч ОПЕК-ийн гишүүн орнууд олборлолтоо 6-р сар хүртэл танахаа мэдэгдлээ
- Биткойны ханш 63 мянган ам.долларыг давснаар биткойн майнинг компаниудын хувьцааны ханш өслөө

Dow Jones	39,087.39
S&P 500	5,137.07
Nasdaq	18,302.91
DAX	17,735.00
FTSE 100	7,682.50
S&P/ASX 200	7,745.60
HANG SENG	16,634.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.23%	0.05%	1.84%	3.71%	17.06%	24.10%
S&P 500	0.80%	1.33%	3.93%	7.70%	26.98%	33.71%
Nasdaq	1.14%	1.87%	4.34%	8.42%	39.23%	25.97%

2024 оны 03 сарын 04-ны 10:00



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.00%	1.79%	4.92%	5.87%	13.84%	27.40%
FTSE 100	0.69%	-0.02%	0.91%	-0.66%	-3.33%	15.87%

2024 оны 03 сарын 04-ны 10:00



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.08%	1.13%	1.49%	1.96%	6.26%	15.33%
Hang Seng	-0.60%	-0.62%	6.59%	-3.02%	-19.62%	-43.19%

2024 оны 03 сарын 04-ны 10:00



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Өнгөрсөн долоо хоногийг АНУ-ын голлох индексүүд бүгд өсөлттэйгөөр хаагдсан бөгөөд S&P 500 индексийн хувьд 2019 оноос хойш хамгийн үзүүлэлт сайтай жилийн эхний 2-р сар болоод байна. Тухайлбал, энэ он эхэлснээс хойш S&P 500 индекс 7.70 хувийн өсөлтийг үзүүлсэн нь томоохон технологийн секторын компаниудын ханшийн өсөлтийн үр дүн юм.

Түүнчлэн, өнгөрөгч Пүрэв гарагт АНУ-ын Худалдааны Яамнаас эрхлэн гаргадаг PCE индекс буюу Хувийн хэрэглээний зардлын индекс зарлагдсан байна. 2024 оны 1-р сарын байдлаар суурь PCE индекс өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулбал 2.8 хувь гарч хүлээлттэй нийцсэн байна. Тус индекс нь АНУ-ын FED-ийн инфляцийг хэмжихэд ашигладаг голлогч шалгуур үзүүлэлтийн нэг юм.

Суурь PCE индекс хүлээлтийн дагуу гарсан хэдий ч АНУ-ын Холбооны банкны эрх баригчдын байр суурь бодлогын хүүг бууруулж эхлэх рүү хараахан шилжээгүй байна гэдгийг тэмдэглэж болохоор байна. CME Group-ээс тооцоолон гаргадаг бодлогын хүүгийн хүлээлтийн хуваарилалт 5.00%/95.00% буюу дараагийн Нээлттэй захын хорооны уулзалтаар бодлогын хүү хэвээр 5.25-5.50 хувь дээр тогтоно гэсэн дийлэнхийн хүлээлттэй байна.

График 1: Lockheed Martin Corporation компанийн хувьцааны ханш /сараар/



АНУ 2024 оны батлан хамгаалахын зардалаа 842 тэрбум ам.долларт хүргэж, өмнөх төсөөллөөс 5% өсгөөд байгаа ба геополитикийн эрсдэлийн түвшин нэмэгдэж байгаа нь батлан хамгаалах, агаарын цэргийн технологийн компанийн хувьцааны ханшид зэрэгээр нөлөөлж болзошгүй.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ-ын зах зээлийн 2-р сарын тоон мэдээллүүд тус улсын эдийн засгийн ойрын ирээдүйн талаар тодорхой дүгнэлт гаргах бололцоог хараахан олгохгүй байна. Өнгөрөгч сарын албан ёсны аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2-р сарын хувьд 49.1 гарсан нь эдийн засгийн уналт болон сэргэлтийн зааг болох 50-ийн түвшнийг давж чадаагүй байна. Түүнчлэн, 2-р сард 10 гаруй өдөр үргэлжилсэн баяр наадмын амралтууд аж үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлжээ. БНХАУ-ын Статистикийн хорооны өгөгдөл дээр суурилдаг албан ёсны PMI индекс доогуур гарсан хэдий ч Caixin агентлагаас эрхлэн гаргадаг PMI үзүүлэлт хүлээлтээс дээгүүр буюу 50.9-тай гарсан байна.

Хятадын үл хөдлөхийн салбарын уналт үргэлжилсээр байна. China Real Estate Corp мэдээлж буйгаар 2024 оны 2-р сард БНХАУ-ын үл хөдлөхийн салбарын TOP 100 компанийн борлуулалтын нийлбэр дүн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 60% буурсан нь өнгөрсөн сарын үзүүлэлтийг ойролцоогоор 2 дахин нугалсан тоон үзүүлэлт юм. Тус улсын Засгийн газар өнгөрөгч Баасан гарагт 200 тэрбум юанийн хөгжүүлэлтэд зориулагдсан зээлийн хөтөлбөрийг баталгаажуулсан нь үл хөдлөхийн салбарын хөрвөх чадварыг сайжруулах зорилготой байна.

График 2: Xinyi Solar компанийн хувьцааны ханш



Өнгөрсөн мягмар гарагт компанийн 2023 оны цэвэр ашиг 9.6 хувь өсөж HKD 4.19 тэрбум буюу USD 535.2 сая хүрсэн байна. Deutsche Bank болон Jefferies санхүүгийн байгууллагууд тус үзүүлэлтүүд нь цэвэр ашгийн хүлээлтийг давсан гэдгийг мэдэгджээ.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers		

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers		

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.